ANNEX 19
TO THE CONVENTION ON INTERNATIONAL CIVIL AVIATION



ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ УЛСЫН ХӨТӨЛБӨР
STATE SAFETY PROGRAMM - SS

1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлага

Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн Хавсралт 19 /ICAO Annex 19/ “Аюулгүй ажиллагааны удирдлага”-ийн дагуу, тус конвенцид нэгдэн орсон улс орон бүр нь Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний хөтөлбөрийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байх шаардлагатай юм.

“Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр” гэж томъёолсон баримт бичгийн хүрээнд тухайн улс орон бүр нь иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, осол, зөрчлийг шинжлэн шалгах, аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн түвшинг тогтоох, хүлээн зөвшөөрөх, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоотой хамааралтай асуудлаар дэмжлэг үзүүлэх, аюулгүй ажиллагааны мэдээллийн нэгдсэн системийг бий болгох зэрэг олон талын, нэгдсэн цогц үйл ажиллагаанүүдыг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

2013 > 2016 > 2019

2. Аюулгүй ажиллагааны улсын хөтөлбөрийн хамрах хүрээ

1. Улсын /Иргэний нисэхийн салбарын/ аюулгүй ажиллагааны бодлого, зорилт болон шаардлагатай нөөцүүд
2. Улсын /Иргэний нисэхийн салбарын/ аюулгүй ажиллагааны эрсдлийн удирдлага
3. Улсын /Иргэний нисэхийн салбарын/ аюулгүй ажиллагааны баталгаажилт
4. Улсын /Иргэний нисэхийн салбарын/ аюулгүй ажиллагааны дэмжлэг



3. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцооны чухал элементүүд /Critical elements/ болон Аюулгүй ажиллагааны улсын хөтөлбөрийн харилцан уялдаа холбоо:





Энэ удаагийн дугаарыг НААХЗА-ны Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтсээс эрхлэн гаргав.

АГУУЛГА

ЭНЭ ДУГААРТ

БАРИМТ БИЧИГ 2

- **Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны улсын хөтөлбөр**
  - -Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлага
  - -Хамрах хүрээ
  - -Хяналтын тогтолцооны чухал элементүүд /Critical elements/ болон Аюулгүй ажиллагааны улсын хөтөлбөрийн харилцан уялдаа холбоо

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ eҮНЭМЛЭХ СИСТЕМ 4-10

- **eҮнэмлэх** системийн
  - -технологийн
  - -техникийн
  - -нууцлал хамгаалалтын
  - -нөөцлөлт, сэргээлтийн шаардлагууд
- **eҮнэмлэх** системд хэрэглэгч хэрхэн хандах вэ?

МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ШАЛГАЛТАД ШИНЭ СИСТЕМ НЭВТРҮҮЛНЭ 10-11

- Шалгалтын шинэ системийн
  - -давуу тал
  - -бүрдэл
  - -менежмент

Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын мэдээллийн сэтгүүл

Г.Ганхуяг
Менежер
Утас: 28-5112
Гар утас: 9910-5588
И-Мэйл: ggankhuyag@mcaa.gov.mn

Б.Пүрэвсүрэн
Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
Утас: 28-2210, 28-2253
Гар утас: 9161-5500, 9191-2343
И-Мэйл: purevsuren.b@mcaa.gov.mn
altantuul.b@mcaa.gov.mn

У.Булгантайшир
Хэвлэлийн эх бэлтгэгч
Утас: 28-2130
Гар утас: 9999-7467
И-Мэйл: bulgantaishir.u@mcaa.gov.mn

ИНЕГ-ын Хэвлэх цех-д хэвлэв
Хаяг: Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, 10-р хороо,
Буянт-Ухаа, ИНЕГ
www.mcaa.gov.mn





НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ e ҮНЭМЛЭХ СИСТЕМ НЭВТЭРЧ ЭХЭЛЛЭЭ

Монгол Улсын Засгийн газар нь цахим засаглалыг хөгжүүлэх, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд дижитал шилжилтийг хийх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах, төрийн үйлчилгээг цахимжуулсанаар иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр дараах баримт бичгүүдэд тусгасан байдаг. Үүнд:

- "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025"
- "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- "Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны 149 дүгээр тогтоол
- "Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 2018 оны 259 дүгээр тогтоол



Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим засаглал үндэсний хөтөлбөр” болон 2020 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т зам, тээврийн салбарт дижитал шилжилтийг хэрэгжүүлэхээр тусгасан. Зам, тээврийн хөгжлийн яам нь “Зам, тээврийн салбарт цахим шилжилт хийх дэд хөтөлбөр”-ийг боловсруулж байгаа бөгөөд 2021 оноос эхлэн цахим яам болохоор бэлтгэл ажлуудыг хангаж байна.

ИНЕГ нь дижитал шилжилтийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн байгууллагууд дунд анхдагч болсон бөгөөд ИНЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/1022 тоот тушаалаар “Иргэний нисэхийн салбарын дижитал шилжилтийн стратеги төлөвлөгөө” батлагдаж, дараах 3 үндсэн чиглэлээр эрчимтэй хэрэгжүүлж байгаа билээ.

Үүнд:

- Төрийн үйлчилгээ–нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын чиглэлээр төрөөс үзүүлдэг үйлчилгээнүүдийг бүрэн цахимжуулах. Одоогоор үнэмлэхжүүлэлтийн үйл явцыг бүрэн цахимжуулсан “eҮнэмлэх” системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхлээд байна.
- Байгууллагын дотоод үйл явц - Албан хэрэг хөтлөлтөнд тоон гарын үсэг, iMCAA системийг нэвтрүүлж цаасгүй байгууллага болохоор ажиллаж байгаа бол захиргаа, хүний нөөц, санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаануудад Veritech системийг бүрэн нэвтрүүлж байгууллагын дотоод үйл явцуудыг дижитал хэлбэрт шилжүүлж байна. “ИНЕГ-ын дижитал өгөгдлийн нэгдсэн сан”-аар дамжуулан ИНЕГ-ын их өгөгдөл (Big Data)-ийг бүрдүүлж, өгөгдөл/мэдээллийн нэгдсэн урсгал бүхий дижитал платформыг бий болгоно.
- Үндсэн үйлчилгээнүүд (агаарын навигаци, нисэх буудал) – ИНЕГ, ИНҮТ-ийн үзүүлдэг үндсэн үйлчилгээнүүд болох агаарын навигацийн үйлчилгээ болон нисэх буудлын үйлчилгээнүүдэд автоматжуулалт, хиймэл оюун ухаан, машин сургалтыг нэвтрүүлэх ажлуудыг үе шаттайгаар хийхээр ажиллаж байна.

Эдгээр цахим системүүдийг Мэдээллийн технологи, инновацийн алба (МТИА)-аас “Иргэний нисэхийн салбарын дижитал шилжилт” стратеги төлөвлөгөөний дагуу үе шаттай хэрэгжүүлж байна. Тус албаны 2019 оны 7 дугаар сараас хөгжүүлсэн eҮнэмлэх системийг нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын үйл ажиллагаанд ашиглаж эхлэхэд бэлэн боллоо ■



MCAA.GOV.MN

Гадаадын систем үйлдвэрлэгчид дунджаар 250,000 ам доллараар нийлүүлдэг энэхүү системийг дотоод нөөц бололцоогоо ашиглан зардал гаргалгүйгээр, Монгол Улсын нисэхийн аюулгүй ажиллагааны үнэмлэхжүүлэлтийн үйл явцад бүрэн тааруулж хөгжүүлсэнээрээ давуу талтай.

Иргэний нисэхийн ерөнхий газраас Үнэмлэхжүүлэлтийн үйл ажиллагааг цахимжуулах зорилгоор хийсэн энэхүү систем нь “Open platform” учир цаашид гэрчилгээжүүлэлтийн системийг хөгжүүлж нэгтгэснээр нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын цогц систем болох юм.

Үнэмлэх систем нь дараах модулиудаас бүрдэнэ:

- Нисгэгч, нислэгийн удирдагч, нислэгийн мэдээллийн ажилтан, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтнуудын үнэмлэхжүүлэлтийн программ;
- Байцаагчийн дүгнэлт, үзлэг шалгалтын программ;
- Мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигчдийн үнэмлэх, гэрчилгээний нэгдсэн өгөгдлийн сан;
- Ажилтнуудын систем ашиглах ажлын урсгал, нэвтрэх түвшний менежмент;
- ИНЕГ-ийн хэмжээнд ашиглаж байгаа баримт бичгийн онлайн сан;
- Гадны хэрэглэгчийн хандах интерфэйс буюу вэб портал;
- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO) болон олон улс, үндэсний баримт бичгүүдийн eLibrary;
- Уулзалт, шалгалт, үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн цаг авах, шаардлагатай баримт бичиг, материалуудын бүрдэл шалгах программ.

Үнэмлэх систем нь дараах давуу талуудтай:

- ИНЕГ-ын үзүүлдэг үндсэн төрийн үйлчилгээ болох үнэмлэхжүүлэх үйл явцыг нэг цэгээс, хүссэн үедээ, хүссэн газраасаа онлайнаар авах боломжийг бүрдүүлсэн;
- Үнэмлэхжүүлэх үйл явцад зарцуулах хугацаа, ажлын ачааллыг бууруулна;
- Дижитал өгөгдлийн сан болон цахим файлын сангаас төрөл бүрийн функцээр өгөгдөл/мэдээллийг хайх (search), анализ хийж тайлан, төлөвлөгөө, дүгнэлт гаргана;
- Ажилтнуудыг группуудэд хуваарилах, унших, засвар оруулах, харах, үүсгэх, устгах эрхүүдийг хуваарилснаар хэн ямар өгөгдөлтэй хэрхэн ажиллах эрхийн түвшинг тогтоож ажил үүргийн уялдааг ханган, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангана;



Гадны хэрэглэгчийн хандах интерфэйс буюу вэб портал



eҮнэмлэх системийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Annex 1 - Personnel Licensing, Doc 9734 – Safety Oversight Manual, Doc 8335 – Manual of Procedures for Operations Inspection, Certification and Continued Surveillance баримт бичгүүд болон Монгол Улсын Иргэний нисэхийн дүрэм 61, 63, 65, 66, 67-д нийцүүлэн хөгжүүлсэн.







Системийн хөгжүүлэлтийн явцад гадаадын нийлүүлэгч компаниуд (vendors)-ын Empic, SOMS, eAuthority, CASR, Aspeq гэх мэт ижил төстэй системүүдийг судалсан.



***eУнэмлэх** систем нь дараах технологийн шаардлагуудыг хангасан байна:*

- Программ хангамжийн бүтэц нь JEE сервер дээр тулгуурласан, Java clients-ийг ашигласан байна. Мөн JBossаппликейшн сервер болон Oracle (BEA) Weblogic-ийг дэмждэг бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад аппликейшн серверийг дэмждэг хэлбэрээр өөрчлөх боломжтой.
- Гуравдагч талуудын аппликейшнуудыг нэгтгэх боломжтой нээлттэй бүтэцтэй;
- Цахим шуудангийн Interface-ээр дамжуулан MS-Outlook-тай холбогдох боломжтой;
- MS-Outlook (календарь)-тай холбогдон ярилцлага товлох боломжтой;
- MS-Word-тай холбогдон цахим шуудан болон тайлан гаргах боломжтой Interface;
- MS-Excel-тай холбогдон өгөгдөл дамжуулах болон статистик гаргах боломжтой Interface;
- Шалгалтын системүүдтэй 2 урсгалтай Interface-ээр холбогдох боломжтой;
- Архив/Баримт бичгийн менежментийн систем (iMCAA)-тэй холбогдсон Interface;
- Аппликейшн серверээр дамжуулан олон түвшинтэй нэвтрэх менежмент.
- Бүх хэрэглэгчийн хийсэн үйлдлүүдийг бүртгэж, мөшгөх боломжтой өгөгдлийн түүх;
- Бар код олгох, таних, унших боломжтой;
- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO) болон олон улс, үндэсний баримт бичгүүдийн eLibrary;

- ***eУнэмлэх системийн техникийн шаардлагууд:***
- Нийт нэвтэрсэн хэрэглэгчийн ашиглалтыг хянах, ашиглалтын түүхийг харуулахаас гадна бичгийн эх хувь болон хавсралтыг сканнераар болон бусад файлын олон төрлөөр оруулдаг:
- Дизайн, харагдах байдлын хувьд хэрэглэгчийн дэлгэцэд мэдээлэл харуулах, оруулахад шаардлагатай цонх, талбар, хүснэгтүүд нь хэрэглэхэд хялбар, энгийн, ойлгомжтой байхаар зохиомжлогдсон:
- Системд гаднаас хандаж байгаа хэрэглэгч өөрийн хүсэлтийг ирүүлж бүртгэл үүсгэсний дараа өөрийн имайл хаягаар хүсэлтийн хариуг хүлээж авахаас гадна, гар утсанд мессэж илгээх байдлаар өөрийн явуулсан хүсэлтийн хариуг түргэн шуурхай авна.
- Системд бүртгэсэн мэдээлэл болон хүсэлтүүдийн өөрчлөлтийн түүхийг хэрэглэгч болон системийн администраторын түвшинд харах, шалгахад хялбар, ойлгомжтой байдлаар загварчилсан байна.

- Өөрчлөлтийн түүхийг зөвхөн харах бөгөөд устгах, засах боломжгүй байна. Мэдээллийг тусгай алгоритмын аргаар кодчилж дамжуулдаг байх ба дундаас нь алдахгүй байх зорилготой аюулгүй байдлын технологитой байна.
- Өөрчлөлтийн түүх нь доорх хэлбэртэй байна:
    - Огноо, цаг минут
    - Хэрэглэгчийн овог нэр
    - Холбогдох мэдээллийг агуулж буй хүснэгт, талбар
    - Хуучин болон шинэ мэдээлэл
    - IP хаяг, холбоо барих утасны дугаар гэх мэт
    - Ажиллагааны мэдээлэл (хариу өгсөн, цаг өгсөн, буцаасан тухай мэдээллүүд)
- Систем нь веб суурьтай үед дурын вэб хөтөч дээр нэмэлт программ хангамж, модулиуд шаардахгүйгээр ажилладаг байх, эсвэл Windows, Android болон iOSүйлдлийн систем дээр ажилладаг байх ба программ шинэчлэгдэх үед өөрөө автоматаар шинэчлэгдсэн хувилбарыг татаж ажиллана.
- Тусгай алгоритмын кодчилол нь нийтлэг хэрэглэгдэж байгаа бүх интернет хөтөч дээр ажилладаг байх.

- ***eYнэмлэх системын нууцлал, хамгаалалтын шаардлага:***
- Систем бүхэлдээ мэдээллийн системийн нууцлал хамгаалалтын ISO/27001 стандартын шаардлагыг хангасан байх шаардлагатай.
- Бүх төрлийн вирус, спам, exploit нэвтрэх боломжийг хаасан байна.
- Хэрэглэгчийн нууц үгийг кодлох бөгөөд кодлох арга нь нэг талын алгоритм байна.
- Системд ажиллаж байх үед сүлжээ болон техник хангамжид гарсан алдаанаас болж мэдээлэл алдагдахгүй байх боломжийг бүрдүүлсэн байна.

- ***eYнэмлэх системийн нөөцлөлт, сэргээлтийн шаардлага:***
- Өгөгдлийн сан дахь өгөгдлийг backup, restore хийдэг байх.
- Системийн мэдээллийн сангийн найдвартай, өндөр нууцлалтай, аюулгүй ажиллагааг хангасан байх бөгөөд тодорхой хугацаануудад автоматаар нөөцлөгддөг байх
- Системийн мэдээллийн санг дурын үед нөөцлөн авах боломжтой байх
- Нөөцлөн авсан мэдээллийн сангуудыг буцаан сэргээхэд нөөцлөх үеийн бүх мэдээлэл хадгалагдан үлдсэн байх бөгөөд нөөцлөлт, сэргээлт хийснээс болж ямар нэг үр дагавар гарахгүй байх

eYнэмлэх системд хэрэглэгч хандах:

- Вэб порталд бүртгүүлэхийн тулд НААХЗА-ны хариуцсан ажилтан Хэрэглэгчийн менежментийн модульд шинээр хэрэглэгч үүсгэх эсхүл тухайн хүн өөрөө нэвтэрч хэрэглэгчээр бүртгүүлэх хүсэлтээ онлайнаар явуулах боломжтой. Вэб хэрэглэгчээр бүртгэсэн талаар болон цаашид хэрхэн нэвтрэх зааварчилгааг цахим шуудангаар хариу явуулна.
- Вэб порталаар дамжуулан үнэмлэх авах хүсэлт (онлайнаар бөглөсөн маягт гэх мэт) явуулах, төлбөр төлөх боломжтой бөгөөд хүсэлт ирсэнээр НААХЗА-ны дотоод үйл явцыг эхлүүлнэ. Тухайн үнэмлэхийг авахад шаардлагатай бүх материалуудыг хавсаргасны дараа хүсэлтийг илгээх боломжтой.

- Вэб порталд холбогдсон вэб хэрэглэгч нь дараах функцуудыг ашиглах боломжтой байна. Үүнд:
  - Нэвтрэх хаягийн менежмент(нэвтрэх нэр, нууц үг);
  - Холбоо барих хаяг болон үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн өгөгдлүүд;
  - Өөрийн холбоо барих хаягийг шинэчлэх;
  - Онлайнаар хүсэлт (хүсэлтийн маягт, мессеж гэх мэт) явуулах;
  - Үнэмлэх, зэрэглэлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл.

- Вэб порталын функцууд нь дараах үйл ажиллагааг гүйцэтгэх боломжтой байна. Үүнд:
  - Хэрэглэгчийн үндсэн цонх (Хэрэглэгч нууц үгээ өөрөө солих боломжтой);
  - Нэвтрэх хаягаа идэвхижүүлэх зааврыг цахим шуудангаар илгээх;
  - Нэвтрэх нэр ба нууц үгээ мартсан тохиолдолд сэргээх;
  - Цахим халдлагаас сэргийлсэн Captcha code;
  - Алдааны мессеж.

- ***Тодорхой нэг хүнд тусгайлан зориулсан хэсэг:***

  Агаарын тээврийн компаниудын тусгайлан томилсон ажилтан, багш шалгагч нисгэгч, эрүүл мэндийн шалгагч эмч гэх мэт гаднаас хандаж буй зөвшөөрөгдсөн этгээд программ хангамжийн холбогдох өгөгдлүүдийг харах болон хариуцсан ажилтнуудтай холбогдох зорилгоор ашиглана. Тухайн ажилтан нь оруулсан мэдээлэлдээ хариуцлага хүлээх компанийн зүгээс зөвшөөрөгдсөн хүн байна.



МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ШАЛГАЛТАД ШИНЭ СИСТЕМ НЭВТРҮҮЛНЭ

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Мэргэжлийн үнэмлэх авахаар хүсэлт гаргагч нараас шалгалт авах олон улсын жишигт нийцсэн шалгалтын шинэ системийг Шинэ Зеланд улсын "Aspeq" байгууллагатай хамтран нэвтрүүлж эхлэх гэж байна.

Энэхүү байгууллага нь Монголын ИНЕГ-ын өмнөөс шалгалтын асуултуудыг мэргэжлийн өндөр түвшинд боловсруулж шалгалт авах үйлчилгээг үзүүлэх юм. Шинэ систем нэвтэрснээр ИНД-ийн бүх шаардлагыг хангаад зогсохгүй гэрээнд заасны дагуу "Aspeq" компани ямар нэгэн нэмэлт төлбөр шаардахгүйгээр асуултуудыг тогтмол хугацаанд шинэчилж байх юм.

Тус системийг нэвтрүүлснээр мэргэжлийн үнэмлэхний шалгалт өгөх хүсэлт гаргагч нь ИНЕГ-ын цахим хуудас болон eҮнэмлэх системээр дамжуулан бүртгүүлж, шалгалтын сэдвээ сонгох, зааварчилгаа авах, захиалга хийх болон цуцлах боломжтой. ИНЕГ-ын хувьд цахим хуудсаар шалгалтыг давхар хянах боломжийг бүрдүүлсэн. Мөн ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллага нь "ИНД-66"-ийн дагуу шалгалт өгөх өргөдөл гаргагчдын өмнөөс мэдээлэл оруулах эрхийг олгох боломжтой.

Шалгалтын шинэ системийн давуу тал:

- Иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан шалгалтын асуултын санг бүрдүүлж олон улсын жишигт хүрсэн шалгалтыг авах боломж бүрдэнэ;
- Өргөдөл гаргагчийн онолын мэдлэгийг бодитоор үнэлэх орчин бүрдэнэ;
- Шалгалт өгөх мэдээлэл, бүртгэлийг цахим байдлаар авдаг болсноор өргөдөл гаргагчийн хувьд хялбар үйлчилгээг авах боломжтой;
- Шалгалтын ямар сэдвээр онолын мэдлэгийн шаардлага хангахгүй тухай тайланг “Knowledge deficiency report” өргөдөл гаргагч, сургалтын байгууллага болон ИНЕГ авах боломжтой;
- Сургалтын байгууллагын сургалтын чанарыг бодитоор үнэлэх, үнэлүүлэх боломж бүрдэнэ;
- Мэргэжлийн үнэмлэх олгоход тавигдах шаардлага дээшилснээр салбарын аюулгүй ажиллагааны үндэс болсон боловсон хүчний мэдлэг ур чадвар дээшилнэ.

Шалгалтын систем нь дараах зүйлээс бүрдэнэ:

Өргөдөл гаргагчийн цахим хуудас: *https://mcaa.aspeqexams.com*

- Цахимаар бүртгүүлэх;
- Шалгалт өгөх захиалга хийх;
- Төлбөр төлөх;
- Шалгалтын үр дүнгээ цахимаар харах.

Шалгалтын менежмент:

- Шалгалтын үр дүнгийн талаар санал өгөх;
- Шалтгалтын дараа ямар сэдвээр мэдлэгийн төвшин хангахгүй байгаа тухай тайлан гаргах Knowledge Deficiency Report (KDR);
- Статистик дүн шинжилгээ;
- Шалгалтын асуултыг санамсаргүй байдлаар асуултын сангаас хуваарилах.

https://mcaa.aspeqexams.com



Доорх холбоос орж Шалгалт хэрхэн явагддаг талаарх бичлэгийг үзнэ үү.

http://tasman-media.aspeqexams.com/aslnz/ASP401_-_NZ_Quadrant_Candidate_User_Guide.mp4

AVIATION CROSSWORDPUZZLE



Across

3. What instrument shows engine speed?
7. What instrument shows how high the airplane is flying?
8. What turns on the airplane?
9. What force pulls downward on the plane?
10. Nautical miles per hour:
13. This force will slow the forward movement of an airplane through the air:
14. An upward force that acts against gravity because of low air pressure created above the surface of an airplane's wing is?
17. What are the moving panels near each wing tip that bank or roll the plane?
18. How far ahead the pilot can see is called?
20. A navigational instrument used by pilots to determine direction:
21. To follow a course to reach a destination:
22. What are the moving parts of the horizontal tail that pitch the airplane nose up or down?
23. The moving of the nose up or down is?
24. What is the control that changes the engine speed?
25. What is the instrument that shows the speed of the airplane?

Down

1. The instrument that shows how fast the airplane climbs or descends
2. A force created by the engine, that gives the airplane forward motion:
4. The instrument that shows when the airplane is level, banked, climbing or descending:
5. As the speed of moving air increases, the air pressure decreases:
6. A collection of instruments critical for the operation of the airplane:
11. This is controlled by moving the ailerons, resulting in one wing going up and the other down:
12. To slowly drive the plane on the ground is called?
15. What is the maneuver in which the airplane's nose is up slightly, speed is decreased for landing, and the aircraft is positioned for touchdown:
16. What is the highest altitude the airplane is capable of flying called?
19. The steering of the nose either left or right:

Word Bank

attitude indicator
ceiling
yaw
throttle
taxi
knots
instrument panel
thrust
vertical speed indicator
drag
visibility
navigate
tachometer
Pitch
heading indicator
Bernoulli's Principle
gravity
start switch
bank